

Дундговь аймаг дахь
Төрийн аудитын газар



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны жилийн
төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд
хийсэн санхүүгийн тайлангийн аудит

АУДИТЫН КОД:

ДУА-2021/01/-СТА-ТЕЗ

Дундговь дахь Төрийн аудитын газрын
дарга бөгөөд Тэргүүлэх аудиторын
үүргийг түр орлон гүйцэтгэгч
Х.Наранцацрал Утас: 7059-2439

Ахлах аудитор Т.Батсайхан

Аудитор Ж.Угтахбаяр

Утас: 7059-3113

Цахим хаяг: Dundgovi@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим
хуудас: www.audit.mn

Агуулга

1. Аудитын гэрчилгээ.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
3. Аудитын тайлан.....	8
3.1. Ерөнхий зүйл.....	8
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	9
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	9
3.4 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	9
3.5.1 Мөнгөн хөрөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	10
3.5.2 Авлага	10
3.5.3 Бараа материал.....	11
3.5.4 Үндсэн хөрөнгө.....	12
3.5.5 Өр төлбөр.....	13
3.5.6 Засгийн газрын хувь оролцоо	14
3.5.7 Орлогын данс	14
3.5.8 Зардал.....	14
3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаар тайлбар, тодруулга	15
3.7 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	16
3.8. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	17
3.9. Шилэн дансны мэдээлэл	17
3.10. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	17
4. Менежментийн захидал	17
Асуудал 1: Дотоод хяналт	Тэргүүлэх ач холбогдол-1..... 18
Асуудал 2: Дотоод хяналт	Тэргүүлэх ач холбогдол-2..... 19
Асуудал 3: Хууль, тогтоомжийн хэрэгжилт	Тэргүүлэх ач холбогдол-3..... 19
5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	21

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ОНХС	Төсвийн шууд захирагч
СХС	Орон нутгийн хөгжлийн сан
ЭЭС	Сум хөгжүүлэх сан
ЗДТГ	Эмийн эргэлтийн сан
ЕБС	Засаг даргын Тамгын газар
ЭМТ	Ерөнхий боловсролын сургууль
ТЗС	Эрүүл мэндийн төв
ТХДЖТ	Тусгай зориулалтын сан
	Төв халхын дуулалт жүжгийн театр

1. Аудитын гэрчилгээ



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

48090 Дундговь аймаг, Сайнцагаан сум
Утас: 70592439, 70592208, 70593208
И-мэйл: dundgovi@audit.gov.mn

2021.04.19 № 45

танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-т заасны дагуу Дундговь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгад аудит хийлээ.

Дундговь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгад материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Аймгийн Засаг дарга бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэл, Засаг даргын мөрийн хөтөлбөр, түүний биелэлт, бусад санхүүгийн болон санхүүгийн бус мэдээлэл байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

0012020510

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Х.НАРАНЦАЦРАЛ

2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

		/Мянган төгрөг/	
Код:	Тайлангийн үзүүлэлт	2019оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	16,392,988.0	27,203,909.6
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	5,599,608.2	8,720,246.7
33	АВЛАГА	3,801,949.7	5,080,998.0
34	УРЬДЧИЛГАА	0.0	0.0
35	БАРАА МАТЕРИАЛ	6,369,622.2	7,393,579.7
36	НӨӨЦИЙН БАРАА	140,926.4	211,186.7
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	480,881.6	5,797,898.6
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	141,226,145.3	145,698,452.4
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	141,226,145.3	145,698,452.4
39100	Газар	0.0	0.0
39200	Биет хөрөнгө	114,550,932.8	118,981,614.0
39300	Биет бус хөрөнгө	26,675,212.5	26,716,838.4
39400	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	0.0	0.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	157,619,133.3	172,902,362.1
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	4,626,735.0	10,074,587.5
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	547,336.8	645,154.1
41300	Өглөг	547,254.1	645,154.1
41400	Урьдчилж орсон орлого	82.7	0.0
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	4,079,398.2	9,429,433.4
42100	Урт хугацаат үнэт цаас	0.0	0.0
42200	Урт хугацаат зээл	4,079,398.2	9,429,433.4
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	152,992,398.3	162,827,774.6
51	Засгийн газрын хувь оролцоо	152,992,398.3	162,827,774.6
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	77,870,408.8	77,300,847.4
51200	Хуримтлагдсан үр дүн	28,442,988.2	38,871,735.9
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	46,679,001.3	46,655,191.2
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	157,619,133.3	172,902,362.1

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

		/Мянган төгрөг/	
Код:	Тайлангийн үзүүлэлт	2019оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	57,814,596.2	74,324,949.0
11	ТАТВАРЫН ОРЛОГО	5,172,860.8	5,912,012.5
110	Орлогын албан татвар	3,667,836.4	4,267,933.5
1100	Хувь хүний орлогын албан татвар	4,045,960.4	4,580,278.7
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-378,123.9	-312,345.2
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	0.0	0.0
1103	ААН-ын орлогын албан татвар	0.0	0.0
1104	Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар	0.0	0.0
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	0.0	0.0
113	Хөрөнгийн албан татвар	403,755.9	443,920.2
114	Нэмэгдсэн өртгийн албан татвар	0.0	0.0
115	Онцгой албан татвар	0.0	0.0
116	Тусгай зориулалтын орлого	0.0	0.0
117	Гадаад үйл ажиллагааны орлого	0.0	0.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	1,101,268.5	1,200,158.8
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	45,340,420.1	61,422,100.7
120	Нийтлэг татварын бус орлого	9,388,064.2	16,011,998.3
121	Хөрөнгийн орлого	44,471.5	142,722.4
122	Тусламжийн орлого	0.0	0.0
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	35,907,884.4	45,267,380.0
124	Зээлийн орлого	0.0	0.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	7,301,315.2	6,990,835.8
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	48,891,901.4	56,536,638.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	48,891,901.4	56,536,638.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	47,889,908.9	53,253,863.3

Дундговь аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	23,787,076.2	27,489,813.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,004,656.2	3,447,765.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,235,357.1	4,277,753.2
2104	Хангамж, бараа материалын зардал	1,632,274.5	1,652,810.6
2105	Нормативт зардал	1,567,603.2	2,046,216.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	599,306.9	590,352.9
2107	Томилолт, зочны зардал	435,041.8	258,412.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,135,477.5	3,581,052.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,493,115.6	9,909,687.2
211	ХҮҮ	0.0	0.0
212	ТАТААС	144,650.6	421,268.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	857,341.9	2,861,506.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.0	0.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	8,922,694.7	17,788,310.9
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	0.0	1,246.0
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	6,559,320.5	8,347,248.2
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	2,363,374.2	9,442,308.7

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

		/Мянган төгрөг/	
Код:	Тайлангийн үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	54,197,692.3	64,318,348.3
11	ТАТВАРЫН ОРЛОГО	5,172,860.8	5,912,012.5
110	Орлогын албан татвар	3,667,836.4	4,267,933.5
1100	Хувь хүний орлогын албан татвар	4,045,960.4	4,580,278.7
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-378,123.9	-312,345.2
113	Хөрөнгийн албан татвар	403,755.9	443,920.2
118	Бусад татвар, төлбөр, хураамж	1,101,268.5	1,200,158.8
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	316,572.8	318,603.0
1181	Газрын төлбөр	369,824.7	597,964.6
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	414,871.0	283,591.2
1183	Бусад татвар	0.0	0.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	41,711,162.8	51,509,759.2
120	Нийтлэг татварын бус орлого	5,758,806.9	6,099,656.8
121	Хөрөнгийн орлого	44,471.5	142,722.4
122	Тусламжийн орлого	0.0	0.0
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	35,907,884.4	45,267,380.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	7,313,668.6	6,896,576.6
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	42,605,319.6	50,919,073.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	42,605,319.6	50,919,073.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	41,518,416.4	47,621,907.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	24,392,612.4	28,037,848.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,111,182.5	3,515,875.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,389,041.8	4,455,676.3
2104	Хангамж, бараа материалын зардал	2,516,465.9	2,726,527.5
2105	Нормативт зардал	1,682,854.7	1,894,382.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	671,691.4	1,026,190.2
2107	Томилолт, зочны зардал	445,563.6	256,004.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,122,241.2	3,580,046.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,186,762.8	2,129,357.4
211	ХҮҮ	0.0	0.0
212	ТАТААС	262,090.3	432,899.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	824,812.9	2,864,266.3
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	11,592,372.7	13,399,274.9
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	8,600,933.4	8,960,198.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	8,600,933.4	8,960,198.8
2200	Дотоод эх үүсвэрээр	8,600,933.4	8,960,198.8
2260	Гадаад эх үүсвэрээр	0.0	0.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-8,600,933.4	-8,960,198.8
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-1,718,211.4	-1,318,437.6
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	1,718,211.4	1,318,437.6
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	1,273,227.9	3,120,638.5
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	4,326,380.3	5,599,608.2
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	5,599,608.2	8,720,246.7

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

		/Мянган төгрөг/	
Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	149,491,823.3	149,491,823.3
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	470,748.8	470,748.8
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	149,962,572.1	149,962,572.1
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	66,732.6	66,732.6
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	223,430.0	223,430.0
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0
7	Өмчид гарсан өөрчилөлт	376,289.4	376,289.4
8	Зарласан ногдол ашиг	0.0	0.0
9	Тайлант үеийн үр дүн	2,363,374.2	2,363,374.2
10	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	152,992,398.3	152,992,398.3
11	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	152,992,398.3	152,992,398.3
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	297,756.3	297,756.3
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	153,290,154.6	153,290,154.6
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-23,810.1	-23,810.1
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	47,243.2	47,243.2
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0
17	Өмчид гарсан өөрчилөлт	71,878.2	71,878.2
18	Зарласан ногдол ашиг	0.0	0.0
19	Тайлант үеийн үр дүн	9,442,308.7	9,442,308.7
20	2020 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	162,827,774.6	162,827,774.6

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

		/Мянган төгрөг/	
Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	58,127,811.7	49,631,542.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	48,742,718.9	45,429,036.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	47,484,882.5	44,192,645.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	28,021,683.4	27,465,120.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,631,113.3	3,441,410.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,456,546.2	4,280,679.4
2104	Хангамж, бараа материалын зардал	1,388,949.0	1,349,332.4
2105	Нормативт зардал	2,953,731.4	1,894,192.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,386,313.8	2,048,310.4
2107	Томилолт, зочны зардал	303,474.9	259,159.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,730,359.4	1,620,841.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,612,711.1	1,833,598.7
212	ТАТААС	427,962.8	427,962.8
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	96,300.0	96,300.0
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	96,300.0	96,300.0
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	331,662.8	331,662.8
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	331,662.8	331,662.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	829,873.6	808,428.4
2132	Бусад урсгал шилжүүлэг	829,873.6	808,428.4
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	6,981,297.9	2,884,068.2
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	2,403,794.9	1,318,437.6
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	58,127,811.7	51,815,522.5
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	33,799,883.8	31,747,028.9
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	18,737,340.1	17,905,971.3
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	305,719.0	222,337.1
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	305,719.0	222,337.1

34	ХҮНИЙ ХӨГЖИЛ САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	0.0	0.0
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	5,284,868.8	1,940,185.2
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	3,655,294.7
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	5,839,275.1

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Мянган төгрөг/			
Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	ТЕЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		4,004,888.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ		3,125,302.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		2,726,256.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		52,330.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		5,439.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		6,873.3
2104	Хангамж, бараа материалын зардал		190,361.0
2105	Нормативт зардал		25,723.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		127,025.6
2107	Томилолт, зочны зардал		9,891.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		2,058,717.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		249,894.3
212	ТАТААС		175.0
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас		175.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		398,870.5
2132	Бусад урсгал шилжүүлэг		38,463.3
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		360,407.2
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		879,586.7
2200	Дотоод эх үүсвэрээр		879,586.7
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		4,004,889.4
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		4,004,889.4
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		0.4
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0.0
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		0.4

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-т заасны дагуу Дундговь аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн ерөнхийлөн захирагч Ц.Мөнхбат танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 04 дүгээр сарын 01-ээс 2021 оны 04 дүгээр сарын 15-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, ахлах аудитор Т.Батсайхан, аудитор Ж.Угтахбаяр нар гүйцэтгэв.

Дундговь аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дундговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 04 дүгээр сарын 1-ний өдрийн 1/516 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ

Дундговь аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн хөгжлийн бодлого, стратеги төлөвлөгөөнд дараах зорилгыг тусгасан байна. Үүнд:

- Аймгийн эдийн засаг, нийгмийг төр засгийн бодлогод нийцүүлэн уялдаа холбоог хангаж, тэнцвэртэй хөгжүүлэх;
- Орон нутгийн онцлог байдалд тохирсон хөгжлийн хэтийн чиг хандлагыг тодорхойлох;
- Эдийн засаг, нийгмийг хөгжүүлж, байгаль орчны зохистой бодлого явуулснаар бизнес хөгжих таатай орчныг бүрдүүлэх;
- Орон нутгийн нөөц, боломжид тулгуурласан жижиг дунд үйлдвэрлэлийг түлхүү хөгжүүлэх;
- Уул уурхай, аялал жуулчлалын үйлчилгээ зэрэг шинэ салбаруудыг хурдацтай хөгжүүлнэ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд томоохон өөрчлөлт ороогүй.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Дундговь аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох стандарт, журмын дагуу шинэчлэгдсэн байна.

Дундговь аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

Дундговь аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба 2020 онд Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсвийн шууд захирагч, ОНӨААТҮГ-ын нийт 94 байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж, санхүү, нягтлан бодох бүртгэл, худалдан авалтын чиглэлээр нийт 90 зөвлөмж, 8 албан шаардлага, 12 төлбөрийн акт өгсөн байна. Өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 90 хувь, албан шаардлагын хэрэгжилт 85.7 хувь, актын биелэлт 90.9 хувьтай байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгддэг байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 1,446.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн нь өмнөх оноос буурсан ч санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналтыг тайлант хугацааны явцад хийж, жилийн эцсийн тайлан гарахаас өмнө хэрэгжилт, үр дүнг тооцож ажиллах шаардлагатай байна.

3.4 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардлын 65,337.9 сая төгрөгийн 1 хувь буюу 653.4 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд санхүүгийн тайланд устгах бичилт хийгдсэн тул төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшнийг 648.8 сая төгрөг болгон өөрчиллөө.

3.5 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга, аудитын дүн

3.5.1 Мөнгөн хөрөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 5,599.6 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 8,720.2 сая төгрөг болж, 3,120.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Касст байгаа бэлэн мөнгө	1.1	0.1	(1.0)
Банканд байгаа бэлэн мөнгө	5,598.5	8,720.1	3,121.6
Замд яваа мөнгөн хөрөнгө	-	-	-
Хадгаламж	-	-	-
Дүн	5,599.6	8,720.2	3,120.6
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	3,277.2	4,948.4	1,671.2
Төсөл/ сан	1,223.8	1,083.3	(140.5)
Төрийн сан	1,055.2	2,649.8	1,594.6
ТӨҮГ болон ОНӨААТҮГ	43.4	38.7	(4.7)
Дүн	5,599.6	8,720.2	3,120.6

Эх сурвалж: Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 99.5 хувь нь Төрийн санд, 0.5 хувь нь арилжааны банкинд байршиж байна. Үлдэгдэл өмнөх оноос өссөн нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжих ажил хийгдээгүйгээс шалтгаалсан байна.

Аудитын илрүүлэлт:

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудын санхүүгийн тайланд орлогын данстай холбоотой нийт 4.5 сая төгрөгийн зөрчил илэрлээ. Үүнээс материаллаг дүнтэй нийтлэг зөрчлийг дурдвал:

- Тайлант хугацаанд тооцсон 3.5 сая төгрөгийн хүүгийн орлогыг үр дүнгийн тайланд орлогоор тайлагнаагүй. /Луус сумын Сум хөгжүүлэх сан/
- Урлагийн хувцас болон заалны түрээсийн орлого 0.2 сая төгрөгийг касс хариуцсан ажилтан өөрийн арилжааны банкны дансаар хүлээн авч Төрийн сан дахь бүртгэлийн дансанд төвлөрүүлээгүй /Төв халхын дуулалт жүжгийн театр/,
- Түрээсийн орлого 0.1 сая төгрөгийг төвлөрүүлээгүй. /Хулд сумын ЭМТ/

Шийдвэрлэсэн нь: 4.2 сая төгрөгийн зөрчлийг аудитын явцад залруулж, 0.3 сая төгрөгийн зөрчлийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоосон.

3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 3,801.9 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 5,081.0 сая төгрөг болж, 1,279.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 2 Авлагын үлдэгдэл /сая төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	10.8	11.2	0.4
Төлбөртэй үйлчилгээний авлага	12.0	9.8	(2.2)
Дансны авлага / ОНӨААТҮГ /	209.1	215.5	6.4
Татвар НДШ / ОНӨААТҮГ /	1.1	1.1	-
Байгууллагаас авах авлага	402.1	1,314.1	912.0
Хувь хүмүүсээс авах авлага	256.9	308.6	51.7
Зээлийн хүүгийн авлага	23.6	29.6	6.0
ЗГ бусад шатны төсөвт олгосон зээл	-	43.0	43.0
Хувь хүмүүст олгосон зээл	2,207.2	2,498.5	291.3
Хувийн хэвшлийн ААНБ олгосон зээл	679.1	649.6	(29.5)
Дүн	3,801.9	5,081.0	1,279.1
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	579.6	1,522.5	942.9

Төсөл/ сан	3,002.1	3,296.0	293.9
Төрийн сан	-	43.0	43.0
ТӨҮГ болон ОНӨҮГ	220.2	219.5	(0.7)
Дүн	3,801.9	5,081.0	1,279.1

Эх сурвалж: Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын данс өссөн шалтгаан нь цэвэрлэх байгууламжийн ханшийн зөрүүний авлага 43.0 сая төгрөгөөр, цар тахалтай холбоотойгоор худалдан авсан хөрөнгөө тайлант хугацаанд хүлээж аваагүйгээс 484.6 сая төгрөгийг байгууллагаас авах авлагаар, ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн ажлын гүйцэтгэл дутуугаас аж ахуйн нэгж, байгууллагад олгосон санхүүжилтийг тус тус авлагаар бүртгэснээс шалтгаалжээ. Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт авлагын 2.4 хувь буюу 120.9 сая төгрөг нь 5 жилээс дээш насжилттай авлага байна. Дээрх авлага нь эргэн төлөгдөхгүй, найдваргүй болох эрсдэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудын санхүүгийн тайланд авлагын данстай холбоотой нийт 348.3 сая төгрөгийн зөрчил илэрлээ. Үүнээс материаллаг дүнтэй нийтлэг зөрчлийг дурдвал:

- Авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй /Хулд сумын ТЗС 18.7 сая, Говь-Угтаал сумын ОНХС 12.5 сая, Дэрэн сумын ЭЭС 42.6 сая, Сайхан-Овоо сумын ЭЭС 18.8 сая, Сайхан-Овоо сумын ТЗС 22.5 сая/
- Санхүүгийн тайланд авлагыг тусгаагүй, илүү, дутуу зөрүүтэй тайлагнасан /Өндөршил сумын ЭЭС 1.3 сая, Хулд сумын ОНХС 7.5 сая, Луус сумын ИТХ 0.4 сая/
- Сум хөгжүүлэх сангийн хугацаа хэтрэлттэй зээлийн эргэн төлөлт хугацаандаа хийгдээгүй /Адаацаг сумын СХС 8.7 сая, Дэлгэрцогт сумын СХС 12.3 сая, Хулд сумын СХС 46.4 сая, Гурвансайхан сумын СХС 33.9 сая, Эрдэнэдалай сумын СХС 20.4 сая/

Шийдвэрлэсэн нь: Авлагын данстай холбоотой дээрх зөрчлүүдэд 134.8 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 153.4 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 60.1 сая төгрөгийн зөрчлийг аудитын явцад залруулсан.

3.5.3 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 6,991.4 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 13,402.7 сая төгрөг болж, 6,411.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 3 Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалтын материал	1,608.4	1,868.4	260.0
Эм боох материал	220.6	358.9	138.3
Бэлэн бүтээгдэхүүн	6.8	6.8	-
Бичиг хэргийн материал	217.7	287.4	69.7
Аж ахуйн материал	2,459.1	2,905.6	446.5
Сэлбэг хэрэгсэл	63.9	83.1	19.2
Түлш, шатах тослох материал	74.4	101.2	26.8
Барилгын засварын материал	155.6	241.9	86.3
Хүнсний материал	182.7	57.8	(124.9)
Бусад хангамжийн материал	280.4	381.0	100.6
Мал амьтад	1,100.0	1,101.5	1.5
Нөөцийн бараа	621.8	6,009.1	5,387.3
Дүн	6,991.4	13,402.7	6,411.3
Үүнээс, байгууллагын төрлөөр			
Төсөвт байгууллага	6,255.1	12,478.6	6,223.5
Төсөл/ сан	186.3	244.5	58.2
Төрийн сан	-	-	-
ТӨҮГ болон ОНӨҮГ	550.0	679.6	129.6
Дүн	6,991.4	13,402.7	6,411.3

Эх сурвалж: Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант оны эцэст 5,408.0 сая төгрөгийн бараа материалыг төсвийн хөрөнгөөр худалдан авч, үнэ төлбөргүй буюу хандиваар 898.3 сая төгрөг, шилжүүлэн авсан 48.4 сая төгрөг, бусад 58.0 сая төгрөгийн бараа материалаар нэмэгдэж, 5,388.8 сая төгрөгийн бараа материалыг зарцуулж, шилжүүлсэн байна.

Нийт бараа материалын үлдэгдлийн 90.8 хувь нь төсөвт байгууллага болон төсөл сан, 9.2 хувийг ОНӨААТҮГ эзэлж байна. Өвөлжилтийн бэлтгэл хангах зорилгоор Мал хамгаалах санд 211.2 сая төгрөгийн өвс нөөцөлжээ:

Аудитын илрүүлэлт:

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудын санхүүгийн тайланд бараа материалын данстай холбоотой нийт 60.2 сая төгрөгийн зөрчил илэрлээ. Үүнээс материаллаг дүнтэй нийтлэг зөрчлийг дурдвал:

- Санхүүгийн тайланд бараа материалын үлдэгдлийг зөрүүтэй тайлагнасан / Сайхан-Овоо сумын Соёлын төв 0.3 сая/
- Бараа материалын үлдэгдлийг тооллого хийж баримтжуулаагүй /Луус сумын ЗДТГ 4.6 сая, Хулд сумын ТЗС 21.5 сая/
- Хөрөнгийг /зураг төсөв/ бүртгэлгүй зардлаар тайлагнасан. /Дэрэн сумын ЕБС 0.5 сая, ЗДТГ 10.0 сая/
- Шатахууны зардлыг хяналтгүй зарцуулж, зарцуулалтын тооцоог бодож, баталгаажуулаагүй. /Луус сумын ЗДТГ 0.7 сая, Дэрэн сумын ЭМТ 5.3 сая, ОНӨГ 1.4 сая/

Шийдвэрлэсэн нь: Бараа материалын данстай холбоотой дээрх зөрчлүүдэд 3.9 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 44.5 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 11.8 сая төгрөгийн зөрчлийг аудитын явцад залруулсан.

3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 162,968.0 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 169,693.2 сая төгрөг болж, 6,725.2 сая төгрөгөөр өссөн байна.

Үзүүлэлт	Хүснэгт № 4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга байгууламж	111,760.6	116,165.8	4,405.2
Тээврийн хэрэгсэл	5,169.3	6,024.9	855.6
Машин тоног төхөөрөмж	9,922.5	10,894.9	972.4
Тавилга эд хогшил	5,005.7	5,311.7	306.0
Дуусаагүй барилга	2,229.3	2,228.4	(0.9)
Түүх соёлын дурсгалт зүйл	921.1	926.6	5.5
Номын фонд	663.0	691.9	28.9
Биет бус хөрөнгө	26,848.2	26,877.4	29.2
Бусад үндсэн хөрөнгө	448.3	571.6	123.3
Дүн	162,968.0	169,693.2	6,725.2
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	121,321.0	131,160.0	9,839.0
Төсөл/ сан	15.3	17.3	2.0
Төрийн сан	-	-	-
ТӨҮГ болон ОНӨҮГ	41,631.7	38,515.9	(3,115.8)
Дүн	162,968.0	169,693.2	6,725.2

Эх сурвалж: Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдлийн 75.5 хувийг төсөвт байгууллага, төсөл сан, 24.5 хувийг ОНӨААТҮГ-ын үлдэгдэл эзэлж байна. Нийт хөрөнгийн 81.6 хувийг биет хөрөнгө, 18.4 хувийг газар болон биет бус хөрөнгө эзэлж байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн үндсэн хөрөнгө 1,323.3 сая төгрөг, балансаас баланст шилжүүлэн авсан 2,967.6 сая төгрөг, үнэ төлбөргүй буюу хандиваар авсан 9,551.4 сая

төгрөг, бусад 1,226.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгөөр тус тус нэмэгдэж, 8,343.0 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлж, акталж данснаас хассан байна.

Дуусаагүй барилга дансанд 1,600.0 сая төгрөгийн Төв халхын дуулалт жүжгийн театрын барилга, 200.0 сая төгрөгийн Дэлгэрхангай сумын Хүн эмнэлгийн барилга, 62.9 сая төгрөгийн Өлзийт сумын Ерөнхий боловсролын сургуулийн нэгдсэн халаалтын барилга, Дэлгэрцогт сумын Засаг даргын Тамгын газрын 365.5 сая төгрөгийн цэвэр усны шугам сүлжээний барилгын санхүүжилтийн эх үүсвэр дутагдсантай холбоотой нийт 2,228.4 сая төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудын санхүүгийн тайланд үндсэн хөрөнгийн данстай холбоотой нийт 64.2 сая төгрөгийн зөрчил илэрлээ. Үүнээс материаллаг дүнтэй нийтлэг зөрчлийг дурдвал:

- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ажлыг санхүүгийн тайланд тусгаагүй./Өндөршил сумын ОНХС 9.9 сая, Сум дундын ойн анги 8.1 сая/
- Сангийн хөрөнгөөр худалдан авсан биет бус хөрөнгийг машин тоног төхөөрөмжийн дансанд бүртгэсэн./Дэлгэрхангай сумын ТЗС 9.9 сая/
- Зохиогчийн эрхийг шууд зардалд бүртгэсэн /ТХДЖТ 23.7 сая/

Шийдвэрлэсэн нь: Үндсэн хөрөнгөтэй холбоотой дээрх зөрчлүүдэд 40.5 сая төгрөгийн албан шаардлага, 23.7 сая төгрөгийн зөвлөмжийг тус тус хүргүүлсэн.

3.5.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 4,626.7 сая, эцсийн үлдэгдэл 10,074.6 сая төгрөг болж, 5,447.9 сая төгрөгөөр өссөн байна.

Үзүүлэлт	Хүснэгт № 5 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн /+/, Буурсан/-/
Богино хугацаат өр төлбөр дүн	547.3	645.2	97.9
Өглөг	547.3	645.2	97.9
Ажилчидтай холбогдсон өглөг	17.2	29.3	12.1
Татаас, санхүүжилт, шилжүүлгийн өглөг	-	-	-
Бараа үйлчилгээний зардлын өглөг	46.6	132.4	85.8
Зээлийн хүүгийн өглөг	0.4	0.1	(0.3)
Бусад өглөг	483.0	483.3	0.3
Урт хугацаат өр төлбөр дүн	4,079.4	9,429.4	5,350.0
Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	4,079.4	9,429.4	5,350.0
Нийт дүн	4,626.7	10,074.6	5,447.9
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	2,187.1	2,197.3	10.2
Төсөл, сан	57.9	139.3	81.4
Төрийн сан	-	43.0	43.0
ТӨҮГ болон ОНӨҮГ	2,381.7	7,695.0	5,313.3
ДҮН	4,626.7	10,074.6	5,447.9

Эх сурвалж: Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант оны эцэст 645.2 сая төгрөгийн богино хугацаат өр төлбөр бүртгэгдсэний 74.9 хувь нь бусад өр төлбөр, 20.5 хувь нь бараа үйлчилгээний зардлын өр төлбөр, 4.5 хувь нь ажилчидтай холбогдсон өр төлбөр, 0.1 хувь нь зээлийн хүүгийн өр төлбөр байна.

Богино хугацаат өр төлбөрийн дүнд 222.2 сая төгрөгийн насжилт өндөртэй, материаллаг дүнтэй дараах өр төлбөр байна. Үүнд:

- Сумдын Эмийн эргэлтийн сангийн 57.0 сая төгрөгийн эмийн өр;
- Сайхан-Овоо сумын Мал хамгаалах сангийн 25.6 сая төгрөгийн өвсний өр;
- Сумдын Байгаль хамгаалах сангийн 125.2 сая төгрөгийн нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийн өр;

Урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд Дундговь-Ус ОНӨААТҮГ-ын 2,191.9 сая төгрөгийн Азийн хөгжлийн банкны “Нийтийн аж ахуйг хөгжүүлэх төсөл”-ийн, 5,350.0 сая төгрөгийн Азийн

хөгжлийн банкнаас хэрэгжиж буй цэвэрлэх байгууламжийн, Гурвансайхан сумын 1,887.5 сая төгрөгийн Азийн хөгжлийн банкны “Хот байгуулалтын салбарын төсөл”-ийн хүрээнд үүссэн нийт 7,541.9 сая төгрөгийн өр байна.

Аудитын илрүүлэлт:

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудын санхүүгийн тайланд өр төлбөрийн данстай холбоотой нийт 36.6 сая төгрөгийн зөрчлүүд илэрлээ. Үүнээс материаллаг дүнтэй нийтлэг зөрчлийг дурдвал:

- Санхүүгийн тайлан дахь өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй /Хулд сумын ТЗС 30.4 сая, Гурвансайхан сумын ТЗС 4.7 сая/

Шийдвэрлэсэн нь: Өр төлбөртэй холбоотой дээрх зөрчлүүдэд 0.1 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 35.1 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 1.6 сая төгрөгийн зөрчлийг аудитын явцад залруулсан.

3.5.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 152,992.3 сая, эцсийн үлдэгдэл 162,827.7 сая төгрөг болж, 9,835.3 сая төгрөгөөр өссөн байна.

Үзүүлэлт	Хүснэгт № 7 Засгийн газрын оролцоо /сая төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт -/
ЗГ-ын оруулсан капитал	77,870.4	77,300.8	(569.6)
Хуримтлагдсан үр дүн	28,443.0	38,871.7	10,428.7
Өмнөх үеийн үр дүн	26,079.6	29,429.4	3,349.8
Тайлан үеийн үр дүн	2,363.4	9,442.3	7,078.9
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	46,679.0	46,655.2	(23.8)
			-
Дүн	152,992.4	162,827.7	9,835.3
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	109,614.9	121,479.3	11,864.4
Төсөл, сан	4,364.0	4,494.1	130.1
Төрийн сан	1,055.2	2,649.7	1,594.5
ТӨҮГ болон ОНӨҮГ	37,958.3	34,204.6	(3,753.7)
Дүн	152,992.4	162,827.7	9,835.3

Эх сурвалж: Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл өссөн нь тайлант оны нийт үр дүнгээс шалтгаалжээ.

3.5.7 Орлогын данс

Дундговь аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг 1,337.0 сая төгрөг, туслах үйл ажиллагааны орлогыг 520.0 сая төгрөг, нийт 1,857.0 сая төгрөгөөр баталсан байна.

Гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагааны орлого 1,142.0 сая төгрөг, туслах үйл ажиллагааны орлого 798.2 сая төгрөг нийт 1,940.2 сая төгрөгөөр тайлагнажээ. Орлогын төлөвлөгөө биелсэн нь дараах 3 нэр төрлийн орлогын гүйцэтгэлээс шалтгаалсан байна. Үүнд:

- Ан амьтны нөөц ашигласны төлбөр 6 дахин;
- Ус, рашааны нөөц ашигласны төлбөр 4 дахин;
- Бусад орлого 2.3 дахин давж биелсэн байна.

3.5.8 Зардал

№	Үзүүлэлт	Хүснэгт №6 /сая төгрөг/		
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/ бууралт
1	Бараа, ажил үйлчилгээний зардал	1,836.6	2,726.3	889.70
2	Татаас, урсгал шилжүүлэг	29.10	38.6	9.54
3	Хөрөнгийн зардал	5.40	879.6	874.19
	Нийт дүн	1,871.1	3,644.5	1,773.4

Эх сурвалж: Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа, ажил үйлчилгээний зардлын өсөлт нь шүүхийн шийдвэрийн дагуу олгосон хэлмэгдүүлэлтийн цагаатгалд олгосон нөхөн олговор, Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах зардлын өсөлтөөс шалтгаалсан байна.

Харин хөрөнгийн зардал Нэгдсэн Үндэсний байгууллагаас хэрэгжүүлж буй “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” төслөөс 641.8 сая төгрөгийн хөрөнгийн зардлын санхүүжилттэй холбоотойгоор өссөн байна.

Аудитын илрүүлэлт:

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудын санхүүгийн тайланд зардлын данстай холбоотой нийт 237.8 сая төгрөгийн зөрчил илэрлээ. Үүнээс материаллаг дүнтэй нийтлэг зөрчлийг дурдвал:

- Төсвийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авахдаа гэрээ байгуулаагүй, ажил гүйцэтгүүлсний хөлс олгохдоо гэрээ дүгнэсэн акт үйлдээгүй, бүрдэл дутуу анхан шатны баримтаар зарцуулсан./Адаацаг сумын ЗДТГ 13.7 сая, /

- Сумын хөгжлийн бодлогын баримт бичиг, үндсэн чиглэлд тусгагдаагүй, сумын иргэдийн саналаар дэмжигдээгүй төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн / Говь-Угтаал сумын ОНХС 27.6 сая, Өндөршил сумын ОНХС 33.3 сая /

- Төсвийн хөрөнгөөр үндсэн хөрөнгө, бэлэг дурсгалын зүйлс худалдан авахдаа гэрээ байгуулаагүй, төсвийг хяналтгүй зарцуулсан. /АЗДТГ 59.7 сая /

- Ажил гүйцэтгэх гэрээг зөрчин гэрээг дүгнээгүй, ажлыг хүлээж аваагүй байхад төлбөрийг шилжүүлсэн./АЗДТГ 9.9 сая/

- Орон тоо, цалингийн төсөв батлагдаагүй орон тоонд ажилтан авч цалинжуулан, төсвийг зориулалт бусаар зарцуулсан. /Луус сумын ЭМТ 3.8 сая, Хулд сумын ЕБС 1.0 сая, Аймгийн ЗДТГ 10.8 сая, Цагаандэлгэр ЭМТ 6.8 сая/

- Гэрээгээр гүйцэтгүүлсэн ажлын хөлсийг үндсэн цалингийн зардлаас зарцуулсан./ТХДЖТ 8.3 сая/

Шийдвэрлэсэн нь: Зардалтай холбоотой дээрх зөрчлүүдэд 21.5 сая төгрөгийн төлбөрийн акт, 216.3 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлсэн

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаар тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын 2020 оны төсвийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 58,127.8 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд аймгийн Засаг даргын хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 58,127.8 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 48,742.7 сая төгрөгийг урсгал зардалд, 6,981.3 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 2,403.8 сая төгрөгийг эргэж төлөгдөх зээлд зарцуулахаар баталжээ.

Нийт зардлын 33,799.9 сая төгрөгийг улсын төсвөөс, 305.7 сая төгрөгийг Нийгмийн даатгалын сангаас, 18,737.4 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 5,284.8 сая төгрөгийг төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 31,747.1 сая төгрөгийг улсын төсвөөс, 222.3 сая төгрөгийг Нийгмийн даатгалын сангаас, 17,905.9 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 1,940.2 сая мянган төгрөгийг төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос нийт 51,815.5 сая төгрөгийн санхүүжилтийг авсан нь батлагдсан төсвөөс 6,312.3 мянган төгрөгөөр дутуу байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 49,631.5 сая төгрөг буюу 85.4 хувьтай байна. Хөрөнгийн зардлыг 4,097.2 сая төгрөгөөр дутуу зарцуулсан нь ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх ажлын санхүүжилт хуваарийн дагуу ирээгүй, оны эцэст шийдэгдсэн ч худалдан авалтын тендер зарлагдаагүйн улмаас төлөвлөсөн ажлууд хийгдээгүйтэй холбоотой байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр нийт 4,004.9 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ. Үүнээс бараа ажил үйлчилгээний зардалд 2,726.3 сая, урсгал шилжүүлгийн зардалд 38.6 сая, хөрөнгийн зардалд 879.6 сая нийт 3,644.4 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 360.4 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

3.7 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 115 төсвийн байгууллага, 17 орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, 31 тусгай зориулалтын сан, 15 сумын нэгтгэсэн тайлан нийт 178 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 166 байгууллагыг аудитад хамруулан, 10 байгууллагад итгэл үзүүлэн, 2 байгууллагыг /Баянжаргалан сумын ЭЭС, Дэрэн сумын Эрдэм шинжилгээ, туршилт үйлчилгээний төв/ аудитад хамруулаагүй.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудаас 109 байгууллагыг түүвэрт хамруулж, 57 байгууллагад дүгнэлт хүргүүллээ. Үүнд: “Зөрчилгүй” 50, “Хязгаарлалттай” 6 /Сайхан-Овоо, Гурвансайхан, Хулд сумдын нэгтгэсэн санхүүгийн тайлан, Цагаандэлгэр, Өндөршил сумдын ЗДТГ, Хулд сумын ЭМТ/, “Сөрөг” 1 /Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газар/ дүгнэлт гаргасан байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар дотоод хяналттай холбоотой 2, хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой 1, нийт 3 зөвлөмжийг менежментийн захидлаар хүргүүллээ.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 1,446.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 504.3 сая төгрөгийн 72 алдааг аудитын явцад залруулж, 165.3 сая төгрөгийн зөрчилд 88 төлбөрийн акт тогтоож, 750.0 сая төгрөгийн зөрчилд 196 албан шаардлага, 26.7 сая төгрөгийн алдаа, зөрчилд 19 зөвлөмж өглөө.

Орон нутгийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар

Харьяа төсвийн төвлөрүүлэн захирагчийн 15 байгууллагын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” 12, “Хязгаарлалттай” 3 /Сайхан-Овоо, Гурвансайхан, Хулд сумдын нэгтгэсэн санхүүгийн тайлан/ дүгнэлт гаргасан байна.

Аудитаар нийт 26 алдаа, зөрчил илрүүлснээс 0.01 сая төгрөгийн 1 алдааг аудитын явцад залруулж, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчлийг арилгах 11 албан шаардлага, сумдын нягтлан бодогч, төсвийн шууд захирагч нарын ур чадвар, эрх зүйн мэдлэгийг сайжруулах, насжилт өндөртэй авлагыг барагдуулах ажил зохион байгуулах талаар 14 зөвлөмж хүргүүлээд байна.

Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар

Харьяа төсвийн 115 байгууллагаас 10 байгууллагад итгэл үзүүлж, 64 санхүүгийн тайланг түүвэрт хамруулж, 41 санал дүгнэлт гаргаснаас “Зөрчилгүй” 37, “Хязгаарлалттай” 3 /Цагаандэлгэр, Өндөршил сумдын ЗДТГ, Хулд сумын ЭМТ/, “Сөрөг” 1 /аймгийн ЗДТГ/ дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 903.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 431.0 сая төгрөгийн 50 алдааг аудитын явцад залруулж, 28.1 сая төгрөгийн 46 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 417.4 сая төгрөгийн 146 зөрчилд албан шаардлага, 26.7 сая төгрөгийн 5 алдаа, зөрчилд зөвлөмж хүргүүлээ.

Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын санхүүгийн тайлангийн аудитаар

Харьяа 17 орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрыг аудит хамруулснаас 15 санхүүгийн тайланг түүвэрт хамруулж, 2 санал дүгнэлт гаргахаас “Зөрчилгүй” 1 /Дундговь-Ус ОНӨААТҮГ/, аудитад хамрагдаагүй 1 /Дэрэн сумын Эрдэм шинжилгээ туршилт үйлчилгээ ОНӨААТҮГ/ байгууллага байна.

Аудитаар нийт 144.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 35.0 сая төгрөгийн 11 алдааг аудитын явцад залруулж, 0.2 сая төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 109.1 сая төгрөгийн 22 зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

Тусгай санд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар

Харьяа 31 тусгай сангийн санхүүгийн тайланг түүвэрт хамрууллаа. Аудитаар нийт 399.0 сая сая төгрөгийн 69 алдаа, зөрчил илрүүлснээс 38.4 сая төгрөгийн 10 алдааг залруулж, 137.0 сая төгрөгийн 41 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 223.5 сая төгрөгийн 18 зөрчилд албан шаардлага өглөө.

3.8. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Аудит хийх явцад аж ахуйн нэгж, байгууллагуудаас төсөвт байгууллагуудтай холбоотой авлагын судалгааг гаргуулан авсан. Ган-Илч ХХК-аас ирүүлсэн судалгаагаар төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа 35 байгууллага 149.0 сая төгрөгийн халаалтын өртэй байна. Энэ нь Ган-Илч ХХК нь Эрчим хүчний зохицуулах хорооны 2019 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн “Тариф батлах тухай” 521 дугаар тогтоолын дагуу дулааны эрчим хүчний тарифыг нэмэгдүүлсэнтэй холбоотой байна.

“Тариф батлах тухай” дээрх тогтоол нь 2020 оны төсөв батлагдсанаас хойш гарсан учир Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.5-т зааснаар халаалтын төсөв нэмэгдэж батлагдаагүй ба дээрх байгууллагууд санхүүгийн тайландаа өр төлбөрөөр тусгаагүй нь анхаарал татахуйц асуудал байна.

3.9. ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан нийт 152 мэдээлэл цахим хуудсанд байршуулахаас 93 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээлэл хугацаа болоогүй, 56 мэдээллийг хугацаа хоцроож, 1 мэдээллийг огт байршуулаагүй байна.

3.10. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар нийт 3 зөвлөмж өгснөөс зөвлөмжийг хэрэгжүүлж, хэрэгжилтийг Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 1/1436 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4. Менежментийн захидал

Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар нь аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг төсвийн ерөнхийлөн захирагчид зориулж бэлтгэсэн болно.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Аудитын газрын энэхүү зөвлөмж нь та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь Төсвийн ерөнхийлөн захирагчийн үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан төсвийн ерөнхийлөн захирагч болон санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй цаашид анхаарвал зохих асуудлыг менежментийн захидалд тэргүүлэх ач холбогдолтойгоос нь эхлэн эрэмбэлэн үзүүлэв.

АСУУДАЛ 1: ДОТООД ХЯНАЛТ

ТЭРГҮҮЛЭХ АЧ ХОЛБОГДОЛ-1

Илрүүлэлт

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 1,446.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн. Илэрсэн зөрчлийг дансаар ангилан харуулбал:

- Мөнгөн хөрөнгө данстай холбоотой 5.7 сая төгрөг буюу 0.4 хувь
- Авлагын данстай холбоотой 348.3 сая төгрөг буюу 24.1 хувь
- Бараа материалын данстай холбоотой 60.2 сая төгрөг буюу 4.2 хувь
- Зардлын данстай холбоотой 238.1 сая төгрөг буюу 16.5 хувь
- Орлого данстай холбоотой 4.5 сая төгрөг буюу 0.3 хувь
- Өр төлбөр данстай холбоотой 36.7 сая төгрөг буюу 2.5 хувь
- Үндсэн хөрөнгө данстай холбоотой 64.2 сая төгрөг буюу 4.4 хувь
- НББ-тэй холбоотой 525.4 сая төгрөг буюу 36.3 хувь
- Хууль тогтоомжтой холбоотой 163.1 сая төгрөг буюу 11.3 хувь тус тус эзэлж байна.

Зөвлөмж

Төсөв захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар илэрч буй зөрчлийн агуулгад дүн шинжилгээ хийж, гарсан зөрчлийг арилгах чиглэлээр төлөвлөгөө боловсруулж, санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналтыг тайлант хугацааны явцад хийж, жилийн эцсийн тайлан гарахаас өмнө хэрэгжилт, үр дүнг тооцож ажиллах

Энэ нь УСНББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулгын 27 дугаар зүйлд /Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой. Үнэн зөв толилуулга нь ажил гүйлгээний нөлөөг УСНББОУС-д тодорхойлсны дагуу хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлаар тодорхойлж хүлээн зөвшөөрч шударгаар илэрхийлэхийг шаарддаг.

УСНББОУС-ыг шаардлагатай үед нэмэлт тодотгол хавсралтуудын хамт хэрэглэх нь санхүүгийн тайлангийн үнэн зөв толилуулах үр дүнд хүргэнэ/ заасныг зөрчсөн.

Эрсдэл

- Нягтлан бодох бүртгэлийн бодлого алдагдах
- Дотоод хяналт сулрах
- Хууль, тогтоомж зөрчигдөх

Төсвийн захирагчийн хариу

2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 1/598 дугаар бичгээр санал, тайлбар байхгүй талаар хариу ирүүлэв.

АСУУДАЛ 2: ДОТООД ХЯНАЛТ

ТЭРГҮҮЛЭХ АЧ ХОЛБОГДОЛ-2

Илрүүлэлт

ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэгдсэн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн нийт зөрчлийн 10 хувь буюу 144.2 сая төгрөгийг Эмийн эргэлтийн сангийн санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой зөрчил эзэлж байна. Үүний 50 хувь буюу 72.2 сая төгрөг нь нягтлан бодох бүртгэлтэй холбоотой зөрчил байгаа нь Эм эргэлтийн сангийн санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт сул байна.

Зөвлөмж

Эм эргэлтийн сангийн санхүүгийн үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэл хөтлөлт, дотоод хяналтыг сайжруулах, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулж, цаашид тус сангийн бүтэц зохион байгуулалтыг судалж, оновчтой хэлбэрээр шийдвэрлэх

Эрсдэл

- Дотоод хяналт сулрах
- Хууль, тогтоомж зөрчигдөх
- Албан хаагчдын ажлын хариуцлага сулрах

Төсвийн захирагчийн хариу

2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 1/598 дугаар бичгээр санал, тайлбар байхгүй талаар хариу ирүүлэв.

АСУУДАЛ 3: ХУУЛЬ, ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

ТЭРГҮҮЛЭХ АЧ ХОЛБОГДОЛ-3

Илрүүлэлт

ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэгдсэн тайланд нэгтгэгддэг 67 байгууллагын 37.6 хувь нь шилэн дансны цахим хуудсанд байршуулах мэдээллийг хугацаа хоцроосон, огт мэдээлээгүй зөрчил илэрсэн. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн /Шилэн дансны зарчим/ 4.1.1-т /мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх/, 4.1.3-т /тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх/, 6.1-т /энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан

Зөвлөмж

